

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ТӨААТҮГ-ЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2026/22/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас:51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 51-261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn Анализ старт аудит ХХК-ийн захирал: Н. Энхтуяа Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com
--------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	14
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	14
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	14
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БНКаЗУ	Бүгд найрамдах Казакстан улс
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ОХУ	Оросын холбооны улс
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УИХ	Улсын их хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.ЭНХТӨР ТАНАА

2026.03.16 № 06/729
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,881.7 сая төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулсан авлагаас 401.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Харилцагч нараас хүлээн авсан 527.9 сая төгрөгийн шинжилгээний орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккурэл сууриар бүртгээгүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг 238.6 сая төгрөгөөр зөрүүтэй тооцон бүртгэсэн;
- Худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээг хууль, журмын шаардлагад нийцүүлэн байгуулдаггүй, төлбөрийг урьдчилан шилжүүлдэг, барааг хүлээн авсны дараа гэрээг нөхөн байгуулдаг, нийлүүлэх хугацааг 10-60 хоноогоор хэтрүүлсэн зэрэг 399.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39.5-д “Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийн харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна. Иргэний хуулийн Стандарт бус нөхцөлтэй гэрээ 202.2.2.үүргээ гүйцэтгэхэд хэт урт буюу тодорхой бус, хуульд үл нийцэх хугацаа тогтоосон; 202.2.12.үүргээ зөрчсөнөөс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах нөгөө талын эрхийг хязгаарласан”, заалтуудыг зөрчсөн бөгөөд хөрөнгө, өр төлбөрийг бүрэн, үнэн зөв бүртгэх, тооллогын үр дүнг баталгаажуулах шаардлагыг хангаагүйгээс “Эрх ба үүрэг”, “Оршин байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ нь улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд Монгол улс, ОХУ, БНХАУ, БНСУ ба БНКАЗУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн азийн гүнийн геологийн процесс ба металлогени” Төслийн VI үе шатны төслийн ажлыг 2025-2027 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

БНСУ-ын хамтын ажиллагааны хүрээнд Солонгосын дэвшилтэт технологийн хүрээлэн болон Монгол улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Сангийн яам хоорондын байгуулсан хэлэлцээний тэмдэглэлийн дагуу 2023-2027 онд “Монгол-Солонгосын хамтарсан ховор металлын судалгааны төв байгуулах” төсөл нь буцалтгүй тусламж, хөгжлийн дэмжлэг хэлбэрээр хэрэгжиж байна. Тайлант онд уг төслийн барилгын засварын ажил, тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажлууд бүрэн дуусч, 12 дугаар сард лабораторийн нээлтийн үйл ажиллагааг Солонгос, Монголын Засгийн газрын төлөөллүүд хамтран зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ нь Геологийн баримтын төв архивд төвлөрүүлэн хадгалж буй олон тооны цаасан баримт, тайлан, номын цахим сан үүсгэж, олон нийтэд түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх, архивын холбогдох лавлагаа гаргах зорилго бүхий УИХ-ын 2020 оны 52-р тогтоол “Алсын хараа 2050” хөтөлбөрийн хүрээнд 997.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цахим архив 2022” төслийг хэрэгжүүлж, ажлын тайланг “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл”-д амжилттай хамгаалж, Аж үйлдвэр эрдэс баялгийн сайдын 2025 оны 225 дугаар тушаалаар “Биет бус хөрөнгө”-д бүртгүүлж хүлээлгэн өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын зарим ажлыг сайжруулах, эрчимжүүлэх, хүнд суртлыг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын дүнг үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дүгнэлт гаргах үүргийн хүрээнд тус байгууллагын зарим үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Ерөнхий хянан шалгагчийн 01/56 тоот албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,847,303,027.30	4,004,968,322.59
1.1.2	Дансны авлага	1,981,137,434.19	19,308,061,854.39
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	694,531,782.95	876,967,752.30
1.1.6	Бараа материал	1,665,695,018.87	1,625,586,635.59
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	757,976,212.95	947,752,988.25
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	12,946,643,476.26	26,763,337,553.12
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,282,847,663.13	10,195,792,070.53
1.2.2	Биет бус хөрөнгө	366,215,244.90	366,215,244.90
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,649,062,908.03	10,562,007,315.43
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	22,595,706,384.29	37,325,344,868.55
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	6,899,672,186.09	16,119,831,239.45
2.1.1.3	Татварын өр	489,623,535.44	3,358,946,056.75
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	821,483,571.22	985,018,748.22
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	13,225,949.81	8,319,994.81
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,224,005,242.56	20,472,116,039.23
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	8,224,005,242.56	20,472,116,039.23
2.3	Эздийн өмч		
2.3.1	төрийн	5,749,615,252.73	5,749,615,252.73
2.3.9	Хуримтлагдсан ашиг	8,622,085,889.00	11,103,613,576.59
2.3.12.	Эздийн өмчийн дүн	14,371,701,141.73	16,853,228,829.23
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	22,595,706,384.29	37,325,344,868.55

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	24,047,430,298.56	23,950,864,438.22
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	20,906,968,490.84	19,622,712,948.60
3	Нийт ашиг (алдагдал)	3,140,461,807.72	4,328,151,489.62
4	Түрээсийн орлого	-	13,366,551.60
5	Хүүний орлого	140,445,514.56	388,402,010.48
6	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	15,102,192.70
7	ҮХ борлуулсны олз	-	20,205,000.00
8	Бусад орлого	-	399,999,585.10
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,415,871,459.74	1,874,138,998.93
12	Бусад зардал	91,782,848.36	28,646,879.49
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(95,712.16)	(38,091,970.04)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	675,260.44	(37,761,173.66)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	773,832,562.46	3,186,587,807.38
19	Орлогын татварын зардал	100,615,663.76	368,451,669.79
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	673,216,898.70	2,818,136,137.59
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	673,216,898.70	2,818,136,137.59
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	673,216,898.70	2,818,136,137.59

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,749,615,252.73	8,114,637,040.30	13,864,252,293.03
3	Залруулсан үлдэгдэл	5,749,615,252.73	8,114,637,040.30	13,864,252,293.03
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		673,216,898.70	673,216,898.70
7	Зарласан ногдол ашиг		(165,768,050.00)	(165,768,050.00)
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,749,615,252.73	8,622,085,889.00	14,371,701,141.73
11	Залруулсан үлдэгдэл	5,749,615,252.73	8,622,085,889.00	14,371,701,141.73
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		2,818,136,137.59	2,818,136,137.59
15	Зарласан ногдол ашиг		(336,608,450.00)	(336,608,450.00)
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,749,615,252.73	11,103,613,576.50	16,853,228,829.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мерийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	28,032,600,595.36	12,500,851,561.40
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	26,072,159,485.43	12,146,408,896.70
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,267,055.00	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	18,243,713.00	31,118,567.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,931,930,341.93	323,324,097.70
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	24,808,534,990.01	16,409,944,431.78
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,225,245,137.73	5,122,523,706.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,142,117,078.05	1,440,245,277.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,896,417,193.67	2,048,084,617.95
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	30,829,836.37	16,738,400.90
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,085,009,461.01	2,094,033,303.91
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		1,260,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,338,391,579.88	1,941,650,903.80
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,090,524,703.30	33,450,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага		3,711,958,221.55
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,224,065,605.35	(3,909,092,870.38)
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	141,161,514.56	388,407,487.74
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	716,000.00	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	140,445,514.56	388,407,487.74
2.2	Мөнгөн зарлагын дүн	816,202,555.42	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	454,887,555.42	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	361,315,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(675,041,040.86)	388,407,487.74
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	2,784,030.70	-
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	2,784,030.70	14,970,267.20
3.2	Мөнгөн зарлагын дүн	(168,060,526.11)	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	165,768,050.00	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг		(336,608,450.00)
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(2,292,476.11)	(11,139.27)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(165,276,495.41)	(321,649,322.07)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,383,748,069.08	(3,842,334,704.71)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,463,554,958.22	7,847,303,027.30
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,847,303,027.30	4,004,968,322.59

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын
2025 оны аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			24,188,455.4	23,530,315.2	24,752,632.6	564,177.2	102.3	1,222,317.4	105.2
1	Шинжилгээний ажлын орлого	м.төг	7,795,446.6	8,420,000.0	11,769,221.1	3,973,774.5	151.0	3,349,221.1	139.8
	Чулуун бүтээгдэхүүн борлуулалтын орлого	м.төг	103,580.8	100,000.0	75,215.5	-28,365.3	72.6	(24,784.5)	75.2
	Стандарт загварын борлуулалтын орлого	м.төг	275,366.7	230,000.0	214,523.2	-60,843.5	77.9	(15,476.8)	93.3
	Геологийн судалгааны ажил	м.төг	15,873,036.2	14,680,315.2	12,244,999.4	-3,628,036.8	77.1	(2,435,315.8)	83.4
	Бусад орлого	м.төг	141,025.1	100,000.0	448,673.4	307,648.3	318.2	348,673.4	448.7
2	Нийт орлого	м.төг	24,188,455.4	23,530,315.2	24,752,632.6	564,177.2	102.3	1,222,317.4	105.2
3	Нийт зардал	м.төг	23,414,622.8	23,290,706.0	21,566,044.8	-1,848,578.0	92.1	(1,724,661.2)	92.6
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	1,518,332.0	2,494,988.2	1,847,159.4	328,827.4	121.7	(647,828.8)	74.0
4	Татварын өмнөх ашиг	м.төг	773,832.6	239,609.2	3,186,587.8	2,412,755.2	411.8	2,946,978.6	1,329.9
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	673,216.9	215,648.3	2,818,136.1	2,144,919.2	418.6	2,602,487.8	1,306.8
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	5,035,949.2	4,975,185.8	5,179,810.8	143,861.6	102.9	204,625.0	104.1
	а/ Орлогын татварт	м.төг	507,187.6	23,960.9	137,476.4	-369,711.2	27.1	113,515.5	573.8
	б/ НӨАТ	м.төг	2,343,606.6	2,453,000.0	2,542,593.2	198,986.6	108.5	89,593.2	103.7
	в/ НДШ	м.төг	1,349,538.4	1,742,000.0	1,459,283.0	109,744.6	108.1	(282,717.0)	83.8
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	472,779.9	660,224.9	518,423.7	45,643.8	109.7	(141,801.2)	78.5
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	220,928.3	90,000.0	3,957.9	-216,970.4	1.8	(86,042.1)	4.4
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	1,995.1	3,000.0	10,037.5	8,042.4	503.1	7,037.5	334.6
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	139,913.3	3,000.0	508,039.1	368,125.8	363.1	505,039.1	16,934.6
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	165,768.0	107,824.1	336,608.5	170,840.5	203.1	228,784.4	312.2
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	223.0	223.0	223.0	0.0	100.0	0.0	100.0
9	Нийт цалингийн сан	м.төг	5,768,398.1	6,700,000.0	6,396,651.9	628,253.8	110.9	(303,348.1)	95.5
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	2,155.6	2,503.7	2,390.4	234.8	110.9	(113.4)	95.5
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.96	0.99	0.87	-	-	-	-
12	Хөрөнгө оруулалт	м.төг	1,989,965.1	3,493,464.0	2,120,160.8	130,195.7	106.5	(1,373,303.2)	60.7
13	Нийт авлага	м.төг	3,433,645.4	3,000,000.0	17,974,446.1	14,540,800.7	523.5	14,974,446.1	599.1
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	384,110	384,110	-	-	-
14	Нийт өглөг	м.төг	8,224,005.2	2,500,000.0	14,245,788.2	6,021,783.0	173.2	11,745,788.2	569.8
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	-	-	14,245,788	14,245,788	-	14,245,788	-
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Засгийн газрын 2022 оны 8-р сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоолоор “Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ, “Геологийн төв лаборатори” ТӨААТҮГ-ыг нийлүүлэн “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулсан байна.

Үйлдвэрийн газар нь үндсэн зорилгоо “Монгол орны нутаг дэвсгэрийн газрын хэвлийн геологийн тогтоц, түүний бүтцийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр региональ болон тодорхой талбайн хэмжээнд геологийн бүх шатны судалгааны ажлыг гүйцэтгэж, ашигт малтмалын нөөц, хуримтлалыг тогтоох замаар Монгол Улсын хөгжлийн үндсэн тулгуур болсон уул уурхайн салбарын тогтвортой үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах, хот суурин газар, бүс нутгийн хэмжээнд геоэкологи, гидрогеологи, тектоникийн төрөлжсөн судалгааг гүйцэтгэснээр хүн амьтны амьдрах орчин, газар хөдлөл, хөрсний гулсалттай холбоотой геологийн нэгдсэн тайлан хийж дүгнэлт өгөх, эрдсийн түүхий эдийн шинжилгээний үнэн зөв, баталгаатай үр дүнгээр захиалагч, үйлчлүүлэгчийг хангах, уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хувь хүн хуулийн этгээдийн захиалгаар геологийн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэхэд оршино гэж” тодорхойлсон байна.

Компанийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи, тандан судалгаа, ерөмдлөг болон газрын хэвлийтэй холбоотой сэдэвчилсэн судалгааны ажлыг мөрдөж буй заавар, шаардлага, арга аргачлалын дагуу гүйцэтгэх;
- Улсын төсвийн хөрөнгөөр ашигт малтмал эрэх, хайх ажлыг гүйцэтгэж нөөцийг тогтоох, улсын төсөвт үйлдвэрийн газрын хөрөнгөөр геологи ашигт малтмалын судалгаа болон хайгуулын ажлыг гүйцэтгэх; Бүс нутгийн болон тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд гадаад улс болон олон улсын геологийн судалгаа, эрэл хайгуулын төсөл хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх;
- Палеонтологийн олдвор, газар хөдлөлийн идэвхтэй бүс нутгийн давхарга зүйн болон тектоникийн судалгааг гүйцэтгэж төрийн болон орон нутгийн захиргаанд мэдээлж, цаашид авах хэмжээний талаар зөвлөмж өгөх, харилцан мэдээлэл солилцох;
- Геологийн судалгааны ажлын анхдагч материалыг боловсруулж, шаардлагатай мэдээллийн санг бүрдүүлсэн геологийн бүх шатны судалгааны ажлын тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Геологийн баримтын төв архивд тушаах;
- Эрдсийн түүхий эд, тэдгээрийн баяжмалд эрдсийн найрлага, бүтцийг хими, спектр, минералог, петрограф, минераграфи, рентген флуоресценцийн аргаар тоон болон чанарын шинжилгээг захиалагчийн эрэлт шаардлагад нийцүүлэн өндөр нарийвчлалтайгаар гүйцэтгэх;
- Төрөл бүрийн ашигт малтмалын дээж боловсруулалт, физик, механик шинж чанар, үзүүлэлтүүдийг тодорхойлох судалгаа-шинжилгээний ажил гүйцэтгэх, технологийн туршилт хийх; Монгол улсад эрдэс түүхий эдийн лабораторийн шинжилгээнд чухал шаардлагатай стандартчилсан загвар зохион бүтээх;
- Эрдсийн түүхий эд, цацраг идэвхт ашигт малтмал болон бусад боломжит материалаар холбогдох стандартад нийцүүлэн өөрийн болон захиалагчийн хөрөнгөөр аттестатчилсан стандартчилсан загвар зохион бүтээх, баталгаажуулах,

дотоод гадаадын зах зээлд борлуулах, өнгөт эрдэнийн чулууны хайгуул, олборлолт хийх, тэдгээрээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах;

- Эрх бүхий төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр аж ахуйн нэгжүүдийн ашигт малтмалын олборлолтын явцад хяналтын сорьцлолт авч шинжлэн дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх;
- Эрдсийн түүхий эдийн шинжилгээ хийж байгаа лабораториудын шинжилгээний ажилд Стандарт, хэмжил зүйн газартай хамтран жил бүрийн төлөвлөгөөг гаргаж төлөвлөгөөний дагуу хөндлөнгийн хяналт хийж, холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх;
- Эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу бараа бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтын сорилт шинжилгээ хийж итгэмжлэгдсэн лабораторийн үүргийг гүйцэтгэх;
- Эрдсийн түүхий эдийн экспорт, импортын бүтээгдэхүүнд шинжилгээ хийх;
- Геологийн судалгаа, лабораторийн шинжилгээнд нэвтэрч байгаа дэлхийн улс орнуудын дэвшилтэт техник технологийн нэвтрүүлэх, шинэ арга аргачлал боловсруулан батлуулах;
- Сургалт эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах.

Тус байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд үйл ажиллагааны чиглэлийг геологи, геофизик, геохими, гидрогеологийн региональ болон тандан судалгаа, эрлийн ажлыг гүйцэтгэх, эрсдэлийг түүхий эдийн шинжилгээг мөрдөж буй заавар шаардлага арга аргачлалын дагуу гүйцэтгэх гэж бүртгэсэн байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ыг Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 317 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Үйлдвэрийн газрын удирдлагыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө” гэж заасны дагуу ТӨБЗГ-аас томилж байна.

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийг мөрдлөг болгон ажилладаг.

Тайлант хугацаанд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын нэгж нь 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын удирдлагаар батлуулж, тайлант хугацаанд төлөвлөгөөнд туссан 26 аудитыг бүрэн гүйцэтгэн, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг үйлдвэрийн газрын захиралд тухай бүр танилцуулсан байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант хугацаанд ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлан дах ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн захирлын 2023 оны А/103 дугаар тушаалаар баталсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, хууль дүрэм журамд нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,729.6 сая төгрөгөөр буюу 65.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	7,847,303.0	4,004,968.3	(3,842,334.7)
Авлага	2,675,669.2	20,185,029.6	17,509,360.4
Бараа материал	1,665,695.0	1,625,586.6	(40,108.4)
Урьдчилж төлсөн зардал тооцоо	757,976.2	947,753.0	189,776.8
Үндсэн хөрөнгө	9,282,847.6	10,195,792.1	912,944.4
Биет бус хөрөнгө	366,521.2	366,215.24	-
Нийт хөрөнгө	22,595,706.4	37,325,344.9	14,729,638.5
Өр төлбөр	8,224,005.2	20,472,116.0	12,248,110.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,371,701.1	16,853,228.8	2,481,527.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	22,595,706.4	37,325,344.9	14,729,638.5

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, эздийн өмч дансдад нөлөө бүхий өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл тайлант хугацаанд 4,005.0 сая төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 3,842.3 сая төгрөгөөр буурсан байна. Үүнээс 5.8 сая төгрөг нь

кассанд, 3,999.2 сая төгрөг нь арилжааны банкуудын харилцах дансанд, 2,182.7 сая төгрөг нь жилийн 13.5 хувийн хүүтэй Голомт банкны, 1,201.4 сая төгрөг нь жилийн 9.4 хувийн хүүтэй Хөдөө аж ахуйн банкны хадгаламжийн дансанд байршиж байна. Мөнгөн хөрөнгийн бууралтад төслийн санхүүжилт хүлээгдсэнтэй холбоотойгоор худалдан авалт болон үйл ажиллагааны зардлыг оны эхний үлдэгдлээс санхүүжүүлсэн нь нөлөөлсөн;

- Авлагын дансны үлдэгдэл 20,185.0 сая төгрөг бөгөөд үүний 14,681.4 сая төгрөг (73.0 хувь) нь улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хоёр төслийн санхүүжилтийн авлагаас бүрдэж байна. Үлдсэн хэсгийг насжилт өндөртэй авлага 384.1 сая төгрөг, шинжилгээний ажлын авлага 2,596.1 сая төгрөг, тендерийн гүйцэтгэлийн баталгааны авлага 1,086.5 сая төгрөг, геологийн судалгааны ажлын авлага 547.1 сая төгрөг, ажилчдаас авах авлага 82.4 сая төгрөг, стандарт загвар болон чулуун бүтээгдэхүүний борлуулалтын авлага 32.0 сая төгрөг тус тус бүрдүүлж байна. Авлагын өсөлт нь улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийн санхүүжилт тайлант хугацаанд орж ирээгүйтэй холбоотой;
- Тус байгууллага нь найдваргүй авлагын нөөцийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.2.1-д заасан аргачлалаар тооцож байгуулсан бөгөөд дансны үлдэгдэл нь 101.6 сая төгрөг байна.
- Бараа материалын үлдэгдэл тайлант хугацаанд 1,625.6 сая төгрөг болж, оны эхний үлдэгдэлтэй харьцуулахад 40.1 сая төгрөгөөр буурсан байна. Энэхүү өөрчлөлт нь хэрэгжиж буй төслүүдтэй холбоотойгоор 1,758.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 1,798.3 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой. Бараа материалын нийт үлдэгдлийн 62.0 хувь буюу 995.7 сая төгрөг нь байгууллагын судалгааны үр дүнд бий болж үйлдвэрлэгдсэн стандартчилсан загварын дээж, бэлэн бүтээгдэхүүнээс бүрдэж байна.
- Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 947.8 сая төгрөг болж 189.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд хэрэгжүүлж буй төслийн ажилтай холбоотой гэрээний дагуу урьдчилж төлсөн материал, ажлын хөлсний төлбөр 542.7 сая төгрөг, программ хангамжийн үйлчилгээтэй холбоотой дуусаагүй ажлын төлбөрийн 383.8 сая төгрөгийн санхүүжилт олгосонтой холбоотой.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл тайлант хугацаанд 10,562.0 сая төгрөг болж, өмнөх үеэс 912.9 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд батлагдсан хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 307.3 сая төгрөгийн барилгын их засвар, 351.6 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1,119.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 66.3 сая төгрөгийн тавилга, 9.9 сая төгрөгийн компьютер болон түүний дагалдах хэрэгслийг худалдан авч, үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгасан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 559 дүгээр тогтоолын дагуу анхны өртгөө бүрэн нөхсөн 8.4 сая төгрөгийн өртөгтэй нэг тээврийн хэрэгслийг Баянчандмань АЗЗА ТӨХК-д балансаас балансад шилжүүлсэн. Мөн тус газрын 2024 оны 560 дугаар тогтоолоор анхны өртгөө бүрэн нөхсөн 93.1 сая төгрөгийн өртөгтэй дөрвөн тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдсан.

Түүнчлэн ТӨБЗГ-ын 2025 оны 603 дугаар тогтоолын дагуу анхны өртгөө бүрэн нөхсөн, 63 нэр төрлийн 498.1 сая төгрөгийн өртөгтэй, 475.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг актлан данснаас хассан байна.

ТӨБЗГ-ын 2025 оны 689 дүгээр тогтоолын дагуу анхны өртөг 129.8 сая төгрөг, үлдэгдэл өртөггүй “Ланд-200” маркийн, 1443 УБҮ улсын дугаартай тээврийн хэрэгслийг Дундговь

аймгийн Худалдан авах ажиллагааны газарт балансаас балансад шилжүүлсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 907.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож бүртгэсэнтэй холбоотойгоор уг өөрчлөлтүүд гарсан байна.

- Богино хугацаат өглөгийн дансны үлдэгдэл 20,472.1 сая төгрөг болж, тайлант хугацаанд 12,248.1 сая төгрөгөөр өссөн байна. Нийт өглөгийн дийлэнх хувь нь “Агаарын геофизик-2024”, “5 улс” төслүүдийн 14,631.2 сая төгрөгийн судалгааны ажлын өглөг бөгөөд үлдсэн дүн нь геологийн ажлын өглөг, татварын өглөг, урьдчилж орсон орлого, гүйцэтгэлийн баталгааны болон ажилчидтай холбоотой өглөгөөс бүрдэж байна. Тайлант хугацааны өглөгийн өсөлт нь “Агаарын геофизик-2024” төслийн улсын төсвийн санхүүжилт хүлээгдэж байгаатай холбоотой байна.
- Улсын төсөвт төлөх татварын өр 3,358.9 сая төгрөг байгаагаас 420.2 сая төгрөг нь Геологийн Төв лабораторид 2019 онд хийсэн татварын хяналт шалгалттай холбоотой өглөг байна.
- Эздийн өмч дансны үлдэгдэл 2,481.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны цэвэр ашиг 2,818.1 сая төгрөг, төрийн өмчийн ногдол ашиг 336.7 сая төгрөг төлсөнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 728 тоот тогтоолоор батлахдаа нийт орлогыг 23,530.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 23,290.7 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 3,493,5 сая төгрөгийг төлөвлөж баталсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 246 тоот тогтоолоор цалингийн зардлыг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2025 оны 505 тоот тогтоолоор нийт орлогыг 24,028.5 сая төгрөг, нийт зардлыг 23,777.7 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг 3,683.0 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр 12,059.0 сая төгрөгийн шинжилгээний орлого, 12,245.0 сая төгрөгийг геологийн судалгааны ажлын орлого, бусад орлогоор 448.7 сая төгрөг нийт 24,752.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 21,566.0 сая төгрөгийн зардал гаргаж, 3,186.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 24,752.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,222.3 сая төгрөг буюу 105.2 хувиар биелсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 21,566.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,724.7 сая төгрөг буюу 7.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь шинжилгээний материалын зардал, тоног төхөөрөмжийн сэлбэгийн зардал, цахилгааны зардал, удирдлагын зардал тус тус буурсантай холбоотой байна.

Тайлант онд 3,683.0 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, лабораторийн сэлбэг хэрэгсэл, компьютер техник хэрэгсэл, программ хангамж, баримлгын их засвар, САГ-2026/22/НА-СТА-ТӨҮГ

үйлдвэрлэлийн болон оффисын зориулалттай тавилга эд хогшил, зэрэг нийт 6 төрлийн төсөл арга хэмжээг худалдан авахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,567.1 сая төгрөг буюу 42.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр ашгийг 215.6 сая төгрөг байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,818.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Байгууллагын захирлын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/03 дугаар тушаалаар ажилтны хоолны зардлыг ажлын нэг өдөрт 13.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 2.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.
- ТӨБЗГ-ын 2025 оны А/132, А/33, А/198, А/206, А/210, А-1/1036, А-1/2217 тоод тушаалуудын дагуу БНСУ, ОХУ, БНХАУ, Казакстан улсуудад 8 удаагийн гадаад томилолтоор ажиллаж 108.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Байгууллагын даргын тушаалаар 13 удаа дотоод томилолтоор орон нутагт ажиллаж 178.2 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Биет бус хөрөнгөнд нягтлан бодох бүртгэлийн “Даймонд-5”, цалингийн “Payroll”, шинжилгээний бүртгэлийн “Лимс” зэрэг цогц программ хангамж 97.3 сая төгрөгийн өртгөөр бүртгэгдсэн байна.
- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор худалдан авах ажиллагаа, баримт бичиг боловсруулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, геологи болон лабораторийн мэргэжлийн 40 сургалтуудыг зохион байгуулж 18.3 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Төрийн өмчийн 100 хувийн эзэмшлийн хэмжээ нь улсын бүртгэлийн гэрчилгээнд 5,749.6 сая төгрөгөөр бүртгэгдсэн бөгөөд санхүүгийн тайланд тусгагдсан төрийн өмчийн дүнтэй зөрүүгүй байна. Нийт орон тоо 215 бөгөөд жилийн цалингийн зардал 6,396.6 сая төгрөг байна. Үүнээс захирал, удирдах ажилтан 1 хүн 99.1 сая төгрөг, дунд шатны удирдах албан тушаалтан 32 хүн 791.7 сая төгрөг, гүйцэтгэх албан тушаалтан 183 хүн 5,505.8 сая төгрөгийн цалингийн зардлыг тус тус бүрдүүлж байна.
- ТӨБЗГ-ын 2025 оны 505 тогтоолоор байгууллагын бүтэц орон тоог 223, цалингийн зардлыг 6,700.0 сая төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 215 орон тоотой ажиллаж цалингийн зардалд 6,396.6 сая төгрөг зарцуулсан байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 505 тоот тогтоолоор Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийт 63 төрлийн бараа, ажил, үйлчилгээг 3,683.5 сая төгрөгөөр худалдан авахаар батлуулсан байна.

Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийт 72 төрлийн бараа, ажил үйлчилгээг 4,920.1 сая төгрөгөөр худалдан авахаар батлуулсан байна. Үүнд: 11 төрлийн бараа ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 17 бараа ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар, 44 бараа ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар хийхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтаар 8, харьцуулалтаар 10, шууд худалдан авалтаар 33, нийт 51 төрлийн бараа, ажил үйлчилгээг 3,619.6 сая төгрөгөөр гэрээ байгуулан худалдан авалт хийсэн, 3 сонгон шалгаруулалт амжилтгүй болсон байна.

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын
2025 оны аудитын тайлан

2025 оны санхүүжилтээр 2026 онд он дамжин хэрэгжиж байгаа дараах тендерүүд байна.

№	Тендерийн нэр	Тендер шалгаруулалтын журам	Төсөвт өртөг	Гүйцэтгэл	Шалгарсан байгууллага
1	Лабораторийн тоног төхөөрөмж /Мөнгөн усны анализатор /	Нээлттэй тендер шалгаруулалт	335,000.0	249,780.0	Хазаарбат ХХК
2	Компьютер техник хэрэгсэл	Харьцуулалт	81,500.0	80,884.0	Саммит технологи компьютер ХХК
3	Нүүрсний илчлэг тодорхойлох калориметр	Харьцуулалт	88,000.0	88,000.0	Ашид профит ХХК
4	Ураны стандарт загвар	Нээлттэй тендер шалгаруулалт	180,000.0	178,499.2	Радиашн контрол менежмент ХХК
5	Сервер	Нээлттэй тендер шалгаруулалт	350,000.0	-	Гомдол гарсан
6	Чулуулгийн шаварлаг хувирал болон гаммаспектрометрийн хэмжилт хийх	Харьцуулалт	65,622.0	62,040.0	Басис ХХК
7	Ачааны лифт	Нээлттэй тендер шалгаруулалт	150,000.0	145,000.0	Оакс экспресс монголиа ХХК
8	Геологийн нөөцийн программ	Харьцуулалт	45,000.0	44,000.0	Дата ресурс ХХК
9	Цөмийн шинжилгээний лабораторийн болон барилгын урсгал засвар	Нээлттэй тендер шалгаруулалт	350,000.0	334,306.3	Цагаан удам ХХК, Төгсбаялаг алтай ХХК
	Нийт дүн		1,645,122.0	1,182,509.5	

Худалдан авах ажиллагаа болон дотоод хяналтын ажилтны хүний нөөц тогтвор суурьшил муутай, хөдөлгөөн ихтэй байгаагаас тайлант онд харилцагчидтай байгуулсан “Худалдах-худалдан авах тухай гэрээ”, “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дийлэнх нь гэрээний зорилго, нөхцөл, хугацаа, үнийн дүн тодорхойгүй зэрэг гэрээний эрх зүйн шаардлагыг хангахгүй байна. Энэ нь гэрээний үүргийн хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд хийсэн горим сорилын хүрээнд худалдан авах ажиллагаа, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой 399.6 сая төгрөгийн зөрчлүүдийг таслан зогсоох 4 албан шаардлага хүргүүлсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн тус үйлдвэрийн дотоод хяналтыг сайжруулах, орлого, үндсэн хөрөнгийн элэгдэл, авлагыг үнэн, зөв бүртгэж тайлагнах талаарх өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Анализ старт аудит ХХК-ийн аудитор Ц. Оюунтуул, аудитор Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг, хяналтыг захирал Н. Энхтуяа, дараагийн шатны чанарын хяналтыг ахлах аудитор А.Даваадорж, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 01-03/72 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “өндөр” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 23,145.3 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 117.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилтийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэж зохих үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- 32 винтляторыг БНСУ-ын буцалтгүй тусламжаар солиулсан нь 25.0 сая орчим төгрөгийн зардлыг хэмнэсэн;
- Хүйтэн усны хэвтээ магистрал шугам, дулааны хаалт зэргийг сольж шинэчилснээр цэвэр усны алдагдлыг бууруулж, сард төлдөг цэвэр усны зардлыг 4.0 сая төгрөгөөр бууруулсан;
- RP-4 дэд станцыг иж бүрэн шинэчилж, цахилгааны аюулгүй байдлыг бүрэн ханган, жилийн дүнгээр 72.0 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 29 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан орлого, зарлагын мэдээг мөнгөн хөрөнгийн дансдын дэлгэрэнгүй тайлантай тулгаж үзэхэд орлогын 377.0 сая төгрөгийн 7 мэдээлэл, зарлагын 1,686.9 сая төгрөгийн 18 мэдээлэл ил тод байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3. “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Тайлант онд шинээр ажилд орсон 3 ажилтанд Гүйцэтгэх захирлын 2024 оны 05 дугаар сарын 30-ны А/83 тоот тушаалаар баталсан цалингийн сүлжээнээс илүү дүнгээр үндсэн цалинг тогтоож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.4-т “үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалтны цалинг батлагдсан сүлжээний дагуу тогтоогоогүй зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ-ын дотоод хяналтын алба нь 2025 оны жилийн эцсийн байдлаар санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1 дүгээр хавсралтын 2.3-т “Дотоод

хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино. дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтын алба нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд чиглэсэн хяналт, шалгалтыг эрсдэлийн үнэлгээнд үндэслэн төлөвлөж, тогтмол хэрэгжүүлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт 3: Байгууллагын бараа, ажил, үйлчилгээний худалдан авах гэрээнүүдэд гүйцэтгэгч нь гэрээнд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй тохиолдолд алданги, торгууль ногдуулах зохицуулалт тусгагдаагүй, мөн гэрээний хугацааг тодорхой бус эсхүл үндэслэлгүй урт хугацаагаар тогтоосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39.5-д "Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийн харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна. Иргэний хуулийн Стандарт бус нөхцөлтэй гэрээ 202.2.2.үүргээ гүйцэтгэхэд хэт урт буюу тодорхой бус, хуульд үл нийцэх хугацаа тогтоосон; 202.2.12.үүргээ зөрчсөнөөс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах нөгөө талын эрхийг хязгаарласан" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээг холбогдох хууль, журмын шаардлагад нийцүүлэн байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг аудитад хамруулж 10 дансанд горим сорил хэрэгжүүлэн 6,426.3 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн. Жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар хэрэгжилтийг үнэлэхэд 911.4 сая төгрөгийн 4 алдааг залруулсан байна. Шийдвэрлэгдээгүй 3 зөрчлийг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илэрсэн 465.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоон, 2 албан шаардлага, 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгснөөс аудитын шийдвэрийн хэрэгжилт 84.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	2	4,747.2	2	4,747.2	100.0
2	Албан шаардлага	2	7,054.7	1	7,054.7	100.0
3	Зөвлөмж	2	7,254.1	2	7,254.1	100.0
4	Хариуцлага тооцуулах албан шаардлага	2	445,936.9	1	0.0	50.0
	Нийт дүн	8	464,992.9	6	19,056.0	84.1

Өмнөх оны аудитаар өгсөн 1 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаарлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дансанд 2010-2013 онд ашиглалтад орсон, 2022 онд 2 байгууллагыг нэгтгэхэд Геологийн төв лабораториос дутагдсан хөрөнгө нэрээр үндсэн хөрөнгийн жагсаалтад орсон 12.6 сая төгрөгийн анхны өртөгтэй, 2.5 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий 16 нэр төрлийн 41 ш хөрөнгө дутагдсан үндсэн хөрөнгө гэсэн нэршлээр бүртгэлтэй байна. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, биетээр байхгүй дээрх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авах албан шаардлага;
- Татан буугдсан Геологийн судалгааны төв, Геологийн төв лабораториас шилжин ирсэн, барагдах эсэх нь тодорхойгүй 96 харилцагчтай холбоотой 445.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх үр дүнтэй арга хэмжээ аваагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага;

Иймд дутагдсан үндсэн хөрөнгө, барагдаагүй авлагатай холбоотой асуудлыг дээд шатны төсөв захирагчийн анхааралд хандуулахаар шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар “Агаарын геофизик-2024” төслийн суурь боловсруулалтын зардлыг хойшлуулж бүртгэсэн асуудлын хэрэгжилт, уг бүртгэлийн үнэн зөв, үндэслэл, стандартын шаардлагад нийцсэн эсэхэд горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн “Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ, “Геологийн төв лаборатори” ТӨААТҮГ-ыг нийлүүлэн “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨААТҮГ болгон өөрчлөн байгуулах үед балансаас балансад шилжин ирсэн авлага, хөрөнгөтэй холбоотой дараах асуудлуудыг дээд шатны төсөв захирагчаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Татан буугдсан Геологийн судалгааны төв, Геологийн төв лабораториос шилжин ирсэн, 96 харилцагчтай холбоотой 445.9 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.
- Үндсэн хөрөнгийн дансанд 2010-2013 онд ашиглалтад орсон, 2022 онд 2 байгууллагыг нэгтгэхэд Геологийн төв лабораториос дутагдсан хөрөнгө нэрээр үндсэн хөрөнгийн жагсаалтад орсон 12.6 сая төгрөгийн анхны өртөгтэй, 2.5 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий 16 нэр төрлийн 41 ш хөрөнгө дутагдсан үндсэн хөрөнгө гэсэн нэршлээр бүртгэлтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 24,402.1 сая төгрөгийн 6 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 180.8 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Борлуулсан чулуун бүтээгдэхүүний өртөгт 31.0 сая төгрөгийн удирдлагын зардлыг бүртгэсэн;
- Бараа материалын тооллогоор дутагдсан 4.3 сая төгрөгийг чулуун бүтээгдэхүүний төлбөрийг авлагаар бүртгэхдээ борлуулалтын орлого, борлуулсан барааны өртгийг нэмэгдүүлж бүртгэсэн;
- "Агаарын геофизик 2024" төслийн тайлант хугацааны 12,963.6 сая төгрөгийн судалгааны ажлын орлогыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй;
- "Агаарын геофизик 2024" төслийн тайлант хугацааны 10,954.4 сая төгрөгийн судалгааны ажлын өртгийг дутуу бүртгэсэн;
- "Агаарын геофизик 2024" төслийн судалгааны ажлын Үндэсний геологийн албанаас авах 268.0 сая төгрөгийн авлагыг дутуу бүртгэсэн;

Энэ нь НББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" 15-р заалт: Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1,881.7 сая төгрөгийн 16 зөрчил илэрсэнд 10.4 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 745.6 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, 1,125.7 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 1,881.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшин 117.1 сая төгрөгөөс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын бэлэн мөнгөний кассанд 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хяналтын тооллого хийхэд үлдэгдэл нь 1.6 сая төгрөгөөр дутсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутагдсан мөнгөн хөрөнгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Ажилтны илүү цаг болон шөнийн цагийн нэмэгдлийг олгохдоо дундаж цалин хөлсийг буруу тооцоолсноос 2.6 сая төгрөгийг илүү тооцож олгосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.5-д “Ажилтныг илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол энэ хуулийн 109.1, 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс дээр шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 2.2-т “Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын цалин хөлсөөр тооцно. Энэ тохиолдолд дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулахгүй байж болно. Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцооноор нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулж болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин хөлсийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Байгууллагын захирлын 2025 оны А/32 дугаар тушаалаар нийт 184 ажилтанд 208.3 сая төгрөгийн 2024 оны үр дүнгийн шагнал олгосон байна. Урамшуулал олгосон ажилтнуудын ажилд орсон огноог хөдөлмөрийн гэрээ, цагийн бүртгэл зэрэг анхан шатны баримтаар тулган шалгахад 2025 онд шинээр ажилд орсон 9 ажилтанд 6.1 сая төгрөгийн шагнал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Хөдөлмөрийн дотоод журмын 6.4-т “Ажилтанд улирлын болон жилийн ажлын үр дүнгээр урамшуулалт цалин /үр дүнгийн урамшуулалт/-г харгалзан Захирлын тушаалаар олгож болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшууллыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулсан авлагын үлдэгдлээс 401.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Саксес химикал ХХК-аас нунтаглагч аяга, хийн уут, иргэн Б.Х-ээс төмөр диск, иргэн Б.Э-ээс 37.2 сая төгрөгийн чулуун бүтээгдэхүүний бэлдэц барааг хүлээн авсны дараа гэрээг нөхөн байгуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т “Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана: 39.3.3.төлбөрийн нөхцөл, хугацаа”, Иргэний хуулийн 196 дугаар зүйлийн 196.1-т “Дараахь үндэслэлээр гэрээг байгуулсанд тооцно: 196.1.1. эд хөрөнгө шилжүүлснээр гэрээ байгуулахаар хуульд заасан бол гэрээний гол нөхцөлийн талаар талууд тохиролцож, тухайн эд хөрөнгийг шилжүүлснээр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээг нөхөн байгуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Сомманд ХХК-аас Техникийн жин, автомат шигшүүр, Хастөр ХХК-аас детекторын цонх, Эй би эм файмили ХХК-аас бэлэг дурсгалын хайрцаг зэргийг худалдан авахад 35.3 сая төгрөгийг урьдчилан шилжүүлж, гэрээний заалт зөрчсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын гэрээний заалтыг зөрчсөн зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Балирхангай ХХК-аас 259.1 сая төгрөгийн Долгионы дисперсийн рентген флуоресценцийн спектрометр (WDXRF)- ийн усан хөргүүр, Синержи интернейшнл ХХК-аас дискэн нунтаглагч, Их буянт ХХК-аас өрмийн сэлбэг материал авахад гэрээний бараа нийлүүлэх хугацааг 10-60 хоногоор хэтрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын гэрээний заалтыг зөрчсөн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5. Гадаадын зочид, төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зориулалтаар 12.4 сая төгрөгийн өртөг бүхий 70 ш чулуун бүтээгдэхүүнийг байгууллагын захирлын тушаал, шийдвэргүй зарцуулж удирдлага, борлуулалтын зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т “...бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5-д “Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлэг дурсгалын зориулалтаар захирлын тушаал шийдвэргүй зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

6. Өмнөх аудитаар хүргүүлсэн 719,659.00 (Долоон зуун арван есөн мянга зургаан зуун тавин есөн) төгрөгийн “Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, биетээр байхгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авах, зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх” 2025 оны 09 дүгээр сарын 01-ний дотор хэрэгжүүлэх, 2025 оны 03 дугаар сарын 14-ний 506/АО150458 тоот албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Борлуулалтын орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Харилцагч нараас хүлээн авсан 527.9 сая төгрөгийн шинжилгээний орлогыг нягтлан бодох бүртгэлд аккурэл сууриар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шинжилгээний орлогыг аккурэл сууриар бүртгэх зарчмын дагуу холбогдох тайлант хугацаанд нь хүлээн зөвшөөрч бүртгэх, орлогын бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах.

2. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн хөрөнгийн 2025 оны элэгдлийн тооцоог давтан шалгахад 207.9 сая төгрөгийн элэгдлийг илүү, 30.7 сая төгрөгийн элэгдлийг дутуу тооцон нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоог мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлого, ашиглалтын хугацаа, үлдэх өртгийн үнэлгээтэй нийцүүлэн дахин хянаж, илүү болон дутуу тооцсон элэгдлийг залруулан бүртгэх;

3. Урьдчилж орсон орлого данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийг "Даймонд" программд хөтөлж, захиалга болон борлуулалтын мэдээллийг "Лимис" программаар боловсруулан нягтлан бодох бүртгэлийн систем рүү хөрвүүлэн бүртгэж байна. Гэвч эдгээр хоёр системийн өгөгдөл хөрвүүлэлтийн үр дүнд борлуулалтын авлагыг "авлага" болон "урьдчилж орсон орлого" гэсэн зэрэгцээ бичилтээр бүртгэж байгаа нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, стандартын шаардлагад нийцээгүй байна.

Энэ нь байгууллагын НБББББ-ийн 4.2.5-д "Судалгаа шинжилгээний орлогыг тооцоолсон дүнгээр Дт: Дансны авлага Кт : Үйлчилгээний орлого Кт : НӨАТ-ын өглөг гэж заасны дагуу бичилтийг хийх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: "Лимис" болон "Даймонд" системийн өгөгдөл хөрвүүлэлтийн логик, дансны холболтыг нягтлан бодох бүртгэлийн бодлого, стандартын шаардлагад нийцүүлэн дахин тохируулах, борлуулалтын авлагын бүртгэлийг давхардалгүй, зөв ангиллаар бүртгэх, систем хоорондын мэдээлэл дамжуулалт, бүртгэлийн үнэн зөв байдалд тавих дотоод хяналтыг сайжруулах.

5. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цайны газрын 2025 оны 6-9 дүгээр сарын түрээс болон ашиглалтын зардлын 5.0 сая төгрөгийн авлагыг бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага",

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь өр авлагыг барагдуулж ажиллах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цайны газрын түрээс болон ашиглалтын зардлын 5.0 сая төгрөгийн авлагыг холбогдох гэрээ, тооцооны баримтад тулгуурлан бүртгэлд үнэн зөв тусгаж, цаашид авлагын бүртгэлийг иж бүрэн, хугацаанд нь хөтлөн явуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл нь 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 180.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	1	180,823.6					1	180,823.6				
2	Борлуулсан чулуун бүтээгдэхүүний өртөгт 31.0 сая төгрөгийн удирдлагын зардлыг бүртгэсэн.	1	30,972.4					1	30,972.4				
3	Бараа материалын тооллогоор дутагдсан 4.3 сая төгрөгийг чулуун бүтээгдэхүүний төлбөрийг авлагаар бүртгэхдээ борлуулалтын орлого, борлуулсан барааны өртгийг нэмэгдүүлж бүртгэсэн.	1	4,267.5					1	4,267.5				
4	"Агаарын геофизик 2024" төслийн тайлант хугацааны 12,963.6 сая төгрөгийн судалгааны ажлын орлогыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.	1	12,963,605.1					1	12,963,605.1				
5	"Агаарын геофизик 2024" төслийн тайлант хугацааны 10,954.4 сая төгрөгийн судалгааны ажлын өртгийг дутуу бүртгэсэн байна.	1	10,954,414.6					1	10,954,414.6				
6	"Агаарын геофизик 2024" төслийн судалгааны ажлын Үндэсний геологийн албанаас авах 268.0 сая төгрөгийн авлагыг дутуу бүртгэсэн.	1	268,016.0					1	268,016.0				
	Дүн	6	24,402,099.2					6	24,402,099.2				

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын
2025 оны аудитын тайлан

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Харилцагч нараас хүлээн авсан 527.9 сая төгрөгийн шинжилгээний орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккурэл сууриар бүртгээгүй.	1	527,876.7					1	527,876.7				
2	Байгууллагын үндсэн хөрөнгийн 2025 оны элэгдлийг давтан тооцоолоход 207.9 сая төгрөгийн элэгдлийг илүү, 30.7 сая төгрөгийн элэгдлийг дутуу тооцон бүртгэсэн байна.	1	238.598.7					1	238.598.7				
3	Байгууллага нь нягтлан бодох бүртгэлээ Даймонд программ ашиглан хөтлөдөг бөгөөд захиалга, борлуулалтын мэдээллийг Лимис программаар боловсруулж, нягтлан бодох бүртгэлийн программруу хөрвүүлэн бүртгэдэг байна.Тус 2 программын хөрвүүлэлтээс борлуулалтын авлагын бүртгэл нь авлага, урьдчилж орсон орлого гэсэн бичилтээр бүртгэгдэж байгаа нь НБББББ-тэй нийцэхгүй байна.	1	0					1	0				
4	Мөнгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээг анхан шатны баримтруу тулган шалгахад 93.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт нь төлбөрийн и-баримтгүй байна.	1	93,759.7					1	93,759.7				
5	Байгууллагын бэлэн мөнгөний кассанд 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хяналтын тооллого хийхэд үлдэгдэл нь 1.6 сая төгрөгөөр дутуу байна.	1	1,648.4	1	1,648.4								

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын
2025 оны аудитын тайлан

6	Жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулсан авлагаас 401.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	401,647.3			1	401,647.3					
7	Монлаа ХК-аас авлага барагдуулалтаар хүлээн авсан 4575 УБИ улсын дугаартай Nissan Patrol машины эзэмшигчийн бүртгэлийг Автотээврийн үндэсний төвд хийлгээгүй байна.	1	151,119.2					1	151,119.2			
8	"Геологийн судалгаа шинжилгээний төв" ТӨҮГ-аар нь 2025 онд өндөр насны тэтгэвэрт гарсан 5 ажилтанд Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээний заалтын дагуу байгууллагын даргын тушаалаар 64.3 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Ажилтан тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмжид зориулан тусгай сан байгуулж, зарцуулах талаар НБББББичиг болон Хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүй байна.	1	64,280.0					1	64,280.0			
9	Саксес химикал ХХК-аас аяган нунтаглагч аяга, хийн уут, Иргэн Б.Хэрлэнгээс төмөр диск, Иргэн Б.Энхдөлгөөнөөс Чулуун бүтээгдэхүүний бэлдэц барааг хүлээн авсны дараа гэрээ байгуулсан.	1	37,209.5			1	37,209.5					
10	Сомманд ХХК-с Техникийн жин, автомат шигшүүр, Хастөр ХХК-с детекторын цонх, Эй би эм файмили ХХК-с бэлэг дурсгалын хайрцаг зэргийг худалдан авахад 35.3 сая төгрөгийг урьдчилан шилжүүлж, гэрээний заалт зөрчсөн байна.	1	35,336.0			1	35,336.0					
11	Балирхангай ХХК-с Долгионы дисперсийн рентгенфлуоресценцийн спектрометр (WDXRF)- ийн усан хөргүүр, Синержи интернейшнл ХХК-с дискэн нунтаглагч, Их буянт ХХК-с өрмийн сэлбэг материал авахад гэрээний бараа	1	259,080.0			1	259,080.0					

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын
2025 оны аудитын тайлан

	нийлүүлэх хугацааг 10-60 хоногоор хэтрүүлсэн байна.												
12	Цайны газрын 2025 оны 6-9 дүгээр сарын түрээс болон ашиглалтын зардлын 5.0 сая төгрөгийн авлагыг бүртгэлд тусгаагүй.	1	4,999.2					1	4,999.2				
13	Ажилтны илүү цаг болон шөнийн цагийн нэмэгдлийг олгохдоо дундаж цалин хөлсийг буруу тооцоолсноос 2.6 сая төгрөгийг илүү тооцож олгосон байна.	1	2,576.8	1	2,576.8								
14	Байгууллагын захирлын 2025 оны 02 дугаар сарын 21 -ны өдрийн А/32 тушаалаар 184 ажилтанд 208.3 сая төгрөгийн 2024 оны үр дүнгийн шагнал олгосон байна. Урамшуулал олгосон ажилтнуудын ажилд орсон огноог хөдөлмөрийн гэрээ, цагийн бүртгэл зэрэг анхан шатны баримттай тулган шалгахад 2025 онд орсон 9 ажилтанд 6.1 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	6,140.9	1	6,140.9								
15	Гадаадын зочид, төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зориулалтаар 12.4 сая төгрөгийн өртөг бүхий 70 ш чулуун бүтээгдэхүүнийг байгууллагын захирлын тушаал, шийдвэргүй зарцуулж удирдлага, борлуулалтын зардалд бүртгэсэн байна.	1	12,429.5			1	12,429.5						
16	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, биетээр байхгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авах, зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.									1	1		
	Дүн	16	1,881,701.9	3	10,366.1	5	745,702.3	7	1,125,633.5	1	1		

6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

САГ-2026/22/НА-СТА-ТӨҮГ

Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-ын
2025 оны аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан орлого, зарлагын мэдээг мөнгөн хөрөнгийн дансдын дэлгэрэнгүй тайлантай тулгаж үзэхэд орлогын 377.0 сая төгрөгийн 7 мэдээлэл, зарлагын 1,686.9 сая төгрөгийн 18 мэдээлэл оруулаагүй байна.	1	2,063,839.7					1	2,063,839.7
	Дүн	1	2,063,839.7					1	2,063,839.7
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1	Тайлант онд шинээр ажилд орсон 3 ажилтанд Гүйцэтгэх захирлын 2024 оны 05 дугаар сарын 30-ны А/83 тоот тушаалаар баталсан цалингийн сүлжээнээс илүү дүнгээр үндсэн цалинг тогтоож олгосон байна.	1	10,750.0			1	10,750.0		
2	Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ-ын дотоод хяналтын алба нь 2025 оны жилийн эцсийн байдлаар санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хяналт хэрэгжүүлээгүй.	1	0					1	0
3	Байгууллагын бараа, ажил үйлчилгээний худалдан авах гэрээнд бэлтгэн нийлүүлэгч нь гэрээнд заасан хугацаандаа бараа ажил үйлчилгээг нийлүүлээгүй тохиолдолд алданги торгууль төлөх ямар нэг заалт байхгүй, гэрээний хугацааг тодорхой бус эсвэл хэт урт хугацаагаар тавьдаг зэрэг зөрчил нь холбогдох хууль тогтоомжийн заалттай нийцэхгүй байна.	1	67,995.0			1	67,995.0		
	Дүн	3	78,745.0			2	78,745.0	1	0
	Нийт дүн	4	2,142,584.7			2	78,745.0	2	2,063,839.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 191/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/22/КА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Байгууллагын бэлэн мөнгөний кассанд 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хяналтын тооллого хийхэд үлдэгдэл нь 1,648,439.00 (Нэг сая зургаан зуун дөчин найман мянга дөрвөн зуун гучин есөн) төгрөгөөр дутагдсан зөрчил илэрсэн.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.7 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутагдсан мөнгөн хөрөнгө 1,648,439.00 (Нэг сая зургаан зуун дөчин найман мянга дөрвөн зуун гучин есөн) төгрөгийг Кассын нярав Б.Алтанбаяраар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын захирал (Б.Энхтөр), Ерөнхий нягтлан бодогч (Ш.Амарзаяа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0316 SAG-39.Docx

1526200267



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 192/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/22/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Илүү цаг болон шөнийн цагийн нэмэгдлийг олгоходоо дундаж цалин хөлсийг буруу тооцож 2,576,752.00 (Хоёр сая таван зуун далан зургаан мянга долоон зуун тавин хоёр) төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.5-д "Ажилтныг илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол энэ хуулийн 109.1, 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс дээр шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 2.2-т "Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын цалин хөлсөөр тооцно. Энэ тохиолдолд дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулахгүй байж болно. Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсоноор нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулж болно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3 Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Илүү олгосон цалин хөлс 2,576,752.00 (Хоёр сая таван зуун далан зургаан мянга долоон зуун тавин хоёр) төгрөгийг Цалингийн нягтлан бодогч Б.Уянга, Ерөнхий нягтлан бодогч Ш.Амарзаяа нараар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын захирал (Б.Энхтөр),

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2026\0316.SAG-39.Docx

1526200271



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 193/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/22/НА-СТА -ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын захирлын 2025 оны А/32 дугаар тушаалаар нийт 184 ажилтанд 208,300,000.00 (Хоёр зуун найман сая гурван зуун мянган) төгрөгийн 2024 оны үр дүнгийн шагнал олгосон байна. Урамшуулал олгосон ажилтнуудын ажилд орсон огноог хөдөлмөрийн гэрээ, цагийн бүртгэл зэрэг анхан шатны баримтаар тулган шалгахад 2025 онд шинээр ажилд орсон 9 ажилтанд 6,140,900.00 (Зургаан сая нэг зуун дөчин мянга есөн зуун) төгрөгийн шагнал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" -Хөдөлмөрийн дотоод журмын 6.4-т "Ажилтанд улирлын болон жилийн ажлын үр дүнгээр урамшуулалт цалин /үр дүнгийн урамшуулал/-г харгалзан Захирлын тушаалаар олгож болно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3 Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон цалин хөлс 6,140,900.00 (Зургаан сая нэг зуун дөчин мянга есөн зуун) төгрөгийг Захирал Б.Энхтөр, Ерөнхий нягтлан бодогч Ш.Амарзаяа, нараар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын захирал (Б.Энхтөр) хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9025081411
ATA16087
9025081411

Z:\Akt\2026\0316 SAG-39.Docx

1526200269



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 922/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/22/КА-СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаадын зочид, төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зориулалтаар 12,429,539.00 (Арван хоёр сая дөрвөн зуун хорин есөн мянга таван зуун гучин есөн) төгрөгийн өртөг бүхий 70 ш чулуун бүтээгдэхүүнийг байгууллагын захирлын тушаал, шийдвэргүй зарцуулж удирдлага, борлуулалтын зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т "бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5-д "Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин, бэлэг дурсгалын зориулалтаар бэлэн бүтээгдэхүүнийг зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын Захирал (Б.Энхтөр), ерөнхий нягтлан бодогч (Ш.Амарзаяа) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 9-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9036109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-73.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 923/АО150053

Улаанбаатар хот

САГ-2026/22/МА-СТА-ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Өмнөх аудитаар хүргүүлсэн 719.659.00 (Долоон зуун арван есөн мянга зургаан зуун тавин есөн) төгрөгийн “Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, биетээр байхгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авах, зөрчлийг таслан зогсоож, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх” 2025 оны 09 дүгээр сарын 01-ний дотор хэрэгжүүлэх, 2025 оны 03 дугаар сарын 14-ний 506/АО150458 тоот албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ “Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл Төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг 37.1.13.албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1, 4.2.1.10 Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ.” заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй Ерөнхий нягтлан бодогч Ш.Амарзаяа-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын Захирал (Б.Энхтөр)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 924/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/22/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Балирхангай ХХК-аас Долгионы дисперсийн рентген флуоресценцийн спектрометр (WDXRF)- ийн усан хөргүүр, Синержи интернейшнл ХХК-аас дискэн нунтаглагч, Их буянт ХХК-аас өрмийн сэлбэг материал авахад нийт 259,080,000.00 (Хоёр зуун тавин есөн сая наян мянган) төгрөгийн гэрээний бараа нийлүүлэх хугацааг 10-60 хоногоор хэтрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.8 Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

3. Худалдан авалтын гэрээний заалтыг мөрддөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
4. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын Захирал (Б.Энхтөр), ерөнхий нягтлан бодогч (Ш.Амарзаяа) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-73.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 925/А0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/22/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын бараа, ажил, үйлчилгээний худалдан авах 67,995,000.00 (Жаран долоон сая есөн зуун ерэн таван мянган) төгрөгийн гэрээнүүдэд гүйцэтгэгч нь гэрээнд заасан хугацаанд үүргээ биелүүлээгүй тохиолдолд алданги, торгууль ногдуулах зохицуулалт тусгагдаагүй, мөн гэрээний хугацааг тодорхой бус эсхүл үндэслэлгүй урт хугацаагаар тогтоосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39.5-д "Худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийн харилцааг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулна. Иргэний хуулийн Стандарт бус нөхцөлтэй гэрээ 202.2.2.үүргээ гүйцэтгэхэд хэт урт буюу тодорхой бус, хуульд үл нийцэх хугацаа тогтоосон; 202.2.12.үүргээ зөрчсөнөөс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах нөгөө талын эрхийг хязгаарласан" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.8 Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээг холбогдох хууль, журмын шаардлагад нийцүүлэн байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын Захирал (Б.Энхтөр), ерөнхий нягтлан бодогч (Ш.Амарзаяа) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 926/А0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/22/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шинээр ажилд орсон 3 ажилтанд Гүйцэтгэх захирлын 2024 оны 05 дугаар сарын 30-ны А/63 тоот тушаалаар баталсан цалингийн сүлжээнээс 10,750,000.00 (Арван сая долоон зуун тавин мянган) төгрөгөөр илүү дүнгээр үндсэн цалинг тогтоож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.4-т "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох; Цалингийн сан шинэчлэн батлагдсан байгууллагын захирлын 2024.05.30 А/63 тушаал" -д заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.5 Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан тушаалтны цалинг батлагдсан сүлжээний дагуу тогтоогоогүй зөрчлийг арилгаж биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын Захирал (Б.Энхтөр), ерөнхий нягтлан бодогч (Ш.Амарзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-73.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 927/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/22/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Сомманд ХХК-с Техникийн жин, автомат шигшүүр, Хастөр ХХК-с детекторын цонх, Эй би эм файмили ХХК-с бэлэг дурсгалын хайрцаг зэргийг худалдан авахад 35,336,000.00 (Гучин таван сая гурван зуун гучин зургаан мянган) төгрөгийг урьдчилан шилжүүлж, гэрээний заалт зөрчсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.8 Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын гэрээний заалтыг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын Захирал (Б.Энхтөр), ерөнхий нягтлан бодогч (Ш.Амарзаяа) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 928/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/22/НА-СТА -ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Саксес химикал ХХК-аас нунтаглагч аяга, хийн уут, иргэн Б.Х-ээс төмөр диск, иргэн Б.Э-ээс чулуун бүтээгдэхүүний бэлдэц нийт 37,209,500.00 (Гучин долоон сая хоёр зуун есөн мянга таван зуун) барааг хүлээн авсны дараа гэрээг нөхөн байгуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана: 39.3.3.төлбөрийн нөхцөл, хугацаа", Иргэний хуулийн 196 дугаар зүйлийн 196.1-т "Дараах үндэслэлээр гэрээг байгуулсанд тооцно: 196.1.1. эд хөрөнгө шилжүүлснээр гэрээ байгуулахаар хуульд заасан бол гэрээний гол нөхцөлийн талаар талууд тохиролцож, тухайн эд хөрөнгийг шилжүүлснээр" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээг нөхөн байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын Захирал (Б.Энхтөр), ерөнхий нягтлан бодогч (Ш.Амарзаяа) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 929/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/22/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайланд толилуулсан авлагын үлдэгдлээс 401,647,268.00 (Дөрвөн зуун нэг сая зургаан зуун дөчин долоон мянга хоёр зуун жаран найман) төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:" 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.7 Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨААТҮГ-ын Захирал (Б.Энхтөр), ерөнхий нягтлан бодогч (Ш.Амарзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-73.Docx

1526181303